



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 8/39

Чингис хот

Х.Баярбаатарыг улсын дайчилгаа хариуцсан
нууцын ажилтнаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол улсын засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын дайчилгаа хариуцсан нууцын ажилтнаар Санхүү төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн Х.Баярбаатарыг томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Л.Цэнддорж

Цэргийн штабын тоо бүртгэл
хариуцсан офицер

Гишүүд:

С.Галбадрах


Орон нутгийн хамгаалалт,
сургалт эрхэлсэн офицер

Ц.Мягмар-Ариунаа Архив, бичиг хэргийн
эрхлэгч

3. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэд улсын дайчилгаа хариуцсан нууцын ажилтны ажлыг хариуцуулан олгож байсан 20 хувийн нэмэгдлийг 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн зогсоохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д даалгасугай.

4. Х.Баярбаатарт нууцын нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тооцож 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР